



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Гагнуурчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.
3. Зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09		
		Хувилбар: 1		М.Ганбаатар
		Тушаал № А/162		Сарын өгнөө: 2020 он 1 сар 19 өдөр

ҮЙЛЧЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

ҮЙЛЧЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага	4
Хоёр. Химийн бодистой харьцах.....	4
Гурав. Амрах өрөө, оффис цэвэрлэх	5
Дөрөв. Ариун цэврийн өрөө цэвэрлэх.....	5
Тав. Алслагдсан ажлын байранд очиж цэвэрлэгээ хийх.....	6
Зургаа. Угаалга хийх.....	6
Долоо. Цахилгаан хэрэгсэлтэй харьцах.....	6

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 1.1. Цэвэрлэгээ, үйлчилгээ угаалга хийхтэй холбоотой бүх төрлийн журамтай танилцаж, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, цэвэрлэгээний аргачлал эзэмших сургалтанд хамрагдсан байна.
- 1.2. Хэвийн ажиллагаатай, зориулалтын багаж хэрэгсэл, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байх.
 - Үйлчлэгчийн дүрэмт хувцас
 - Зориулалтын гутал
 - Маск/ амны хаалт/
 - Шаардлагатай ажлын байруудад үсний тор, чихний бөглөө
 - 2 төрлийн резин бээлий:
 - Нимгэн бээлийг эд хогшлын тоос шороо арчихад
 - Зузаан Резинэн бээлийг зөвхөн шал арчихад тус тус хэрэглэнэ
- 1.3. Үйлчлэгч нь энэхүү заавартай танилцсаны дараа ажлаа эхлэх ёстой
- 1.4. Тухайн ажлын байрны шаардлагад тохирсон, өөрийн биеийн хэмжээнд таарсан нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тогтмол, зөв хэрэглэнэ
- 1.5. Цэвэрлэгээнд хэрэглэгддэг бүх бодисын” Хор аюулын лавлах”- тай заавал танилцсан байна
- 1.6. Үйлчлэгч нь өөрийн хуваарьт ажлын байрны аюулгүй байдалд хяналт тавих бөгөөд эвдрэл гэмтэл гарсан, тодорхой тодорхой аюул учруулж болзошгүй зүйл илэрсэн тухай бүрд нь холбогдох хүмүүсд мэдэгдэж даруй засуулах, аюулыг арилгуулах арга хэмжээ авна.

ХОЁР. ХИМИЙН БОДИСТОЙ ХАРЬЦАХ

- 2.1. Цэвэрлэгээний материалын шкаф болон агуулахад ил байрлуулсан цэвэрлэгээ, ариутгалын бодисын хэрэглэх зааварт заасан тун хэмжээний дагуу бодисыг найруулж хэрэглэнэ
- 2.2. Цэвэрлэгээ, ариутгалын бодисын сав нь заавал бодисны нэр шошго, хэрэглэх заавар, тэмдэгтэй байна.
- 2.3. Шошго тэмдэггүй, эсвэл хэрэглэх заавар байхгүй, зориулалтын саванд хийгээгүй цэвэрлэгээ ариутгалын бодисыг хэрэглэж болохгүй.
- 2.4. Бодисыг найруулах үедээ” Материалын аюулгүй байдлын хуудас” –д заавал НБХХ өмссөн байна

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

- 2.5. Хэрвээ нүд рүү үсэрсэн, арьсанд хүрсэн тохиолдолд “Хор аюулыг лавлах” –д заасан арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж бөгөөд эмчид яаралтай очиж үзүүлнэ
- 2.6. Цэвэрлэгээ ариутгалын бодис хэрэглэх явцад харшлын ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл хугацаа алдалгүй шууд удирдлагадаа мэдэгдэн эмчид үзүүлнэ
- 2.7. Хэрэглэж байгаа цэвэрлэгээ, ариутгалын бодисыг зориулалтын бус газар, ил задгай тавьж болохгүй
- 2.8. Ажил дууссаны дараа бодисыг асгарах, ууршихаас сэргийлж сайтар тагласан эсэхийг шалган зориулалтын сав, шүүгээнд хадгална.

ГУРАВ. АМРАХ ӨРӨӨ, ОФФИС ЦЭВЭРЛЭХ

- 3.1. Үзэгдэлт хангалтгүй бол гэрэлтүүлгийг асааж цэвэрлэнэ
- 3.2. Цэвэрлэгээний явцад өөрийн биеийн хэмжээнд тохироогүй овор ихтэй, АА-ны горимд заасан хэмжээнээс / 25кг-аас илүү/ хэтэрсэн эд зүйлийг өргөхгүй байх
- 3.3. Цонхны гадна талыг угаахдаа бүхэл биеэ гаргаж болохгүй бөгөөд зөвхөн гараа гаргаж угаана
- 3.4. Цонхны тавцан дээр гарч зогсох, цонхны бариул, хавтаснаас дүүжигнэж болохгүй
- 3.5. Зогсоогоороо хүрэхгүй 2м хүртэл өндөрт байрласан цонх угаах үедээ шат ашиглах бөгөөд шатыг хөдлөхөөс сэргийлж хүнээр бариулсан байна
- 3.6. Хүчтэй салхи шуургатай үед цонх онгорхой байвал хагарахаас болгоомжлон хааж бүрэн түгжих
- 3.7. Хаалгыг угаахдаа хагас онгойлгосон байна
- 3.8. Халтирч гулгах, бүдэрч унахаас сэргийлж шалыг үргэлж цэвэр, хуурай байлгах бөгөөд шингэн зүйл, хоол асгарсныг арчиж, шил шаазангийн хагархай, хог хаягдлыг дор бүр нь цэвэрлэнэ
- 3.9. Шал угаах үед “Халтирч унах аюултай” анхааруулах тэмдгийг угааж байгаа хэсгийн 2 талд заавал байрлуулсан байна
- 3.10. Коридорыг угаахдаа хүн явах гарц үлдээн хэсэгчлэн угаана
- 3.11. Хана, шал, тавилгыг угааж арчихдаа хадаас, өргөх зэрэг хатгах, гэмтээх зүйлсээс болгоомжлох

ДӨРӨВ. АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ ЦЭВЭРЛЭХ

- 4.1. Үйлчлэгч үсээ шууж боон тор зүүж, амны хаалт, зориулалтын бээлий, гутал өмссөн байна
- 4.2. Химийн бодисын эсрэг хор саармагжуулах шингэн / сүү, шүүс гэх мэт/ заавар журамд заасан хэмжээгээр хэрэглэнэ

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

- 4.3. Ариун цэврийн өрөө цэвэрлэх үедээ “ Энд цэвэрлэгээ хийгдэж байна” гэсэн тэмдгийг тавьсан байх.

ТАВ. АЛСЛАГДСАН АЖЛЫН БАЙРАНД ОЧИЖ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ

- 5.1. Засварын хэсэг, агуулах зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж байгаа ажлын байруудыг цэвэрлэх үедээ шаардлагатай газруудад доорх НБХХ нэмэлтээр өмссөн байна. Үүнд:
- Хамгаалалтын малгай
 - Тунгалаг өнгөтэй хамгаалалтын нүдний шил
 - Хамгаалалтын гутал
 - Цацруулагчтай хантааз, эсвэл цамц
- 5.2. Засварын хэсэг болон агуулах дээр ажиллах үйлчлэгч тухайн хэсэг нэгжийн удирдах албан тушаалтнаас тухайлсан аюулгүй ажиллагааны зааварчилгаа заавал авч ажиллана.

ЗУРГАА. УГААЛГА ХИЙХ

- 6.1. Угаалгын хэсэгт угаалгын тоног төхөөрөмж болон уурын бойлер, уурын индүү ажиллуулах тусгай сургалтанд хамрагдаж, ажиллах эрх авсан үйлчлэгч ажиллана.

ДОЛОО. ЦАХИЛГААН ХЭРЭГСЭЛТЭЙ ХАРЬЦАХ

- 7.1. Цахилгааны шугамын ил гарсан утас, шалбарсан хэсэг, хананаас хөндийрсөн залгуурт хүрч болохгүй
- 7.2. Нойтон гараараа цахилгааны залгуурыг цахилгааны эх үүсвэрээс салгаж болохгүй
- 7.3. Ажиллуулахыг зөвшөөрөөгүй тоног төхөөрөмж, хэрэгсэл, аппарат цахилгаанд залгах, эд ангийг нь оролдохыг хориглоно
- 7.4. Цахилгаан залгуурт хэт олон цахилгаан тоног төхөөрөмж хэрэгсэл залгахыг хориглоно
- 7.5. Машин тоног төхөөрөмжийг ажиллуулж байх үед арчиж цэвэрлэхийг хориглох бөгөөд цахилгаан эх үүсвэрээс бүрэн салгагдсан, ямар ч аюулгүй болгосны дараа хүрч болох зөвшөөрөл өгсөн үед угааж цэвэрлэнэ
- 7.6. Машин тоног төхөөрөмж дээр цэвэрлэгээний материал тавьж орхиж болохгүй
- 7.7. Гэрлийн бүрхүүл, гар хатаагч гэх зэрэг хэрэгслийн тоосыг хуурай алчуураар арчина
- 7.8. Хуванцар болон цацаж шүршдэг цэвэрлэгээний бодисын хоосон савыг тус тусад нь ангилан зориулалтын хогийн саванд хийж тагласан байна

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-09
	Хувилбар: 1

- 7.9. Ариун цэврийн өрөөний хогийн савыг бусад хогтой холихгүй бөгөөд хогийн савыг сулласан даруйд хогийн цэгт хүргэнэ
- 7.10. Тамхины савны хогийг авахдаа гал гарах аюул байгаа эсэхийг сайн шалгаж, хэрэв бүрэн унтраагүй бол ус хийж аюулгүй болсон үед хогийг гадагш гаргаж хогийн саванд хийнэ.